



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 122

Улаанбаатар хот

“Мэргэшлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох
болон үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3, 35.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэргэшлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох болон үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын 1-д заасан журмыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Тогтоолын 1-д заасан журам хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 64 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА



Т.ЖАМБААЖАМЦ

1518000265



МЭРГЭШЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТОМИЛОХ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар мэргэжилтэнд олгох эрхийн төрөл, зэрэглэлийг тогтоох, мэргэшлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох болон тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулахтай холбогдох харилцааг зохицуулна.

Хоёр. Мэргэшлийн зөвлөл

2.1. Мэргэшлийн зөвлөл нь Үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, мэргэшлийн шалгалтыг зохион байгуулах, мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхтэй холбоотой харилцааг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлж буй Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2-т заасан мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд хяналт тавина.

2.2. Мэргэшлийн зөвлөл нь орон тооны бус есөн гишүүдээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос томилно.

2.3. Мэргэшлийн зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг мэргэшлийн зөвлөлийн гишүүдийн хурлаар томилно.

2.4. Мэргэшлийн зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд Хорооны Үнэт цаасны газрын болон сургалт зохион байгуулагч, үнэт цаасны чиглэлээр эрдмийн зэрэг, цолтой багш судлаачдын төлөөлөл орж болно.

2.5. Мэргэшлийн зөвлөлийн хуралдаан нь нийт гишүүдийн дийлэнх олонх нь оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд асуудлыг хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

2.6. Мэргэшлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.6.1. мэргэшлийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг хөтөлж, зөвлөлийн дарга, гишүүдэд танилцуулах;

2.6.2. мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг баталгаажуулах, нийтэд мэдээлэх;

2.6.3. мэргэшлийн зөвлөлийн хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө хуралдаанд хэлэлцэх асуудлын жагсаалтыг Мэргэшлийн зөвлөлийн даргаар батлуулж, хэлэлцэх бичиг баримтын хамт гишүүдэд хүргүүлнэ.

Гурав. Ажил үйлчилгээ явуулах эрх, түүний зэрэглэл

3.1. Мэргэжилтэнд олгох эрхийг түүний эрхлэх ажил, үйлчилгээний төрөл, мэргэшлийн түвшнээс хамаарч дараах чиглэлээр олгоно:

3.1.1. мэргэжилтний эрх;

3.1.2. хөрөнгө оруулалтын эрх;

3.1.3. гүйцэтгэх удирдлагын.

3.2. Мэргэжилтэн нь өөрийн эрхлэх ажил, үйлчилгээний төрлөөс хамаарч дор дурдсан эрхийг

авсан байна. Үүнд:

3.2.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, 24.1.6, 24.1.7, 24.1.8, 24.1.9, 24.1.11-д заасан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд ажиллах үндсэн үйл ажиллагаа явуулах мэргэжилтэн энэ журмын 3.1.1-д заасан эрхийг;

3.2.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2, 24.1.3, 24.1.4, 24.1.5, 24.1.10, 24.1.12, 24.1.13, 24.1.14-т заасан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд ажиллах үндсэн үйл ажиллагаа явуулах мэргэжилтэн энэ журмын 3.1.2-т заасан эрхийг;

3.2.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-24.1.14-т заасан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд ажиллах гүйцэтгэх захирал, газар, хэлтэс, албаны захирал энэ журмын 3.1.3-д заасан эрхийг.

3.3. Мэргэжилтэн нь энэ журмын 3.2-т заасан эрхийг давхар авч болно.

3.4. Холбоо нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.12-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд ажиллах гүйцэтгэх захирал, газар, хэлтэс, алба, нэгж, чиглэлийн захирал, мэргэжилтэнд эрх олгож болно.

3.5. Хороонд үнэт цаасны зах зээлийн чиглэлээр 3-аас доошгүй жил ажиллаж байгаа этгээдэд Мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэж, энэ журмын 3.1-д заасан эрхийг хугацаагүйгээр олгож болно.

Дөрөв. Өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх

4.1. Мэргэжилтний эрх олгох болон аттестатчилах мэргэшлийн сургалт, шалгалттай холбоотой өргөдлийг Мэргэшлийн зөвлөл хүлээн авч, шийдвэрлэнэ.

4.2. Шалгуулагч шалгалтын дүнтэй санал нийлэхгүй, шалгалтын тесттэй холбоотой өргөдлийг шалгалтын дүн зарлагдсанаас хойш ажлын гурван өдөрт багтаан Мэргэшлийн зөвлөлийн даргад бичгээр ирүүлнэ.

4.3. Мэргэшлийн зөвлөл өргөдлийг ажлын гурван өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.

4.4. Шалгалтын дүнтэй холбогдсон маргаан гарвал Мэргэшлийн зөвлөлийн дарга магадлах ажлын хэсгийг томилон, материалыг дахин шалгуулах эрхтэй бөгөөд тухайн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Мэргэшлийн зөвлөл шийдвэр гаргана.

4.5. Мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Санхүүгийн зохицуулах хороонд гомдол гаргах эрхтэй.

ооОоо